



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 01 дугаар сарын 29

№ 01/02 ДУА-2018/05/СТА-ТЧЗ Мандалговь хот

Г

Төлбөр барагдуулах тухай

7

Аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Соёлын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар **34,400.00** /Гучин дөрвөн мянга дөрвөн зуун/ төгрөгийн дараах зөрчил илрэлзээ. Үүнд:

1. Үнэт цаасны тооцоо дутуу бодсоноос үндсэн үйл ажиллагааны орлогыг 34,400.00 төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д /төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн касстаа болжээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн одорт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана/, аймгийн Засаг даргын 2009 оны 97 дугаар захирамжаар батлагдсан “Үнэт цаас, тасалбарын маягт хэвлүүлэх, бүртгэх, зарцуулах журам”-ын 3.6-д /Төлбөрт үйлчилгээ, хураамж хураах тухай бүр хариуцсан ажилтанд үнэт цаас, тасалбарын маягтыг актаар хүлээлгэн өгч орсон орлого, зарцуулагчын тайлланг тогтолц болон төлбөрт үйлчилгээ узүүлсний дараах ажлын 1 одрийн дотор гаргуулан тооцоо бодож, орлогыг байгууллагын дансанд тушаалгаж байна/ гэж заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д /Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, биеэ даасан эрхийн актаар зохицуулагдаг сан хөтөлбөр батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлэгүй/ мөн тус журмын 3.1.3-д /Бусад өгөх төлбөр тооцоог зориутай тооцоолж олгосон/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. **34,400.00** /Гучин дөрвөн мянга дөрвөн зуун/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100081235090 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх:
2. Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Соёлын төвийн төсвийн шууд захирагч Н.Баярмаа, Нягтлан бодогч Г.Бум-Аюуш нарт хариуцуулав.

### АКТЫГ

#### ТОГТООСОН<sup>1</sup>:

АУДИТОР:



#### ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ:

НЯГТЛАН БОДОГЧ:

Н.БАЯРМАА

Г.БУМ-АЮУШ



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.